



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/301

Есөнбулаг сум

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 4.1.23 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4, 6.5, 6.6 дэх хэсэг, аймгийн онцгой комиссын 2026 оны 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Өлгий аймагт малын гоц халдварт шүлхий өвчин (SAT-1) гарсантай холбогдуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Бургастайн боомтоор орох хөдөлгөөнд хяналт тавьж, ариутгал халдваргүйтгэл хийж ажиллахыг Алтай сумын Засаг дарга (Г.Гансүх), Хилийн бургастайн боомт хариуцсан төлөөлөгч (Д.Цэрэвсамбуу), Гаалийн хорооны дарга (Д.Эрдэнэсүх) нарт даалгасугай.

3. Зэрлэг ан амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөн, Баян-Өлгий, Ховд аймгийн говиор зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Говийн их дархан цаазат газрын Б хэсгийн хамгаалалтын захиргааны дарга (Н.Алтансүх)-д даалгасугай.

4. Ховд аймагтай хил залгаа Бугат, Тонхил, Дарив, Хөхморьт, Баян-Уул сумын мал эмнэлгийн үржлийн тасаг, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангитай хамтран хөдөлгөөнт эргүүл ажиллуулж, малчдын хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг тухайн сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, малчдад соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, гарын авлага, мэдээллээр тасралтгүй хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах), сум, багийн Засаг дарга нарт даалгасугай.

6. Барлагийн ам, Далан түрүүнд хяналтын цэг ажиллуулж, үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг

Онцгой байдлын газар (хурандаа Ц.Лувсанжамц), Цагдаагийн газар (хурандаа Д.Бүрэнбаатар), Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах) нарт даалгасугай.

7.Хурдан морины бүсийн уралдааныг тодорхойгүй хугацаагаар хориглож, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Морин спорт уяачдын холбоо (Ц.Саруултөгс)-д даалгасугай.

8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, Онцгой комиссын хурлыг тухай бүр шуурхай хуралдуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

